



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан)¹

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫГ ҮНДЭСЛЭЖ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАН НЬ ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/0020

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 02 дугаар сарын 10 өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, Давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, шалгалтын улсын байцаагч нь нэхэмжлэгч Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)-д хийсэн хяналт шалгалтаар тус ББСБ нь “... банк” ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр 12 сарын хугацаатай 3,000,000,000 төгрөгийн зээлийн шугамын гэрээ байгуулж, зээл авсан болохыг тогтоосон байна. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын улсын байцаагч нь нэхэмжлэгч ББСБ-г Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д нэмэлтээр оруулсан 3.22.4² дэх заалтыг зөрчсөн тул Зөрчлийн тухай хуулийн 11.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг³ үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн шийтгэлийн хуудсаар 20,000,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

Тус шийтгэлийн хуудсыг нэхэмжлэгч ББСБ нь эс зөвшөөрч, дээрх журамд нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө зээлийн шугамын гэрээ байгуулж, зээл авсан бөгөөд уг нэмэлт өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд бүртгээгүй тул хүчин төгөлдөр болоогүй гэж үзэж Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газрын улсын байцаагчийн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Харин хариуцагч Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, шалгалтын улсын байцаагчийн зүгээс тус журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь нийтээр дагаж мөрдөх

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3476?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1.

² Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 3.22.4 дэх заалт “дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх” гэжээ.

³ Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 11.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.



хэм хэмжээ тогтоогоогүй, хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй тул бүртгүүлэх шаардлагагүй гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүхээс:** “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁴, 19 дүгээр зүйлийн 19.1⁵, Зөрчлийн тухай хуулийн 11.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргийг гомдол гаргагч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэх хүрээнд хуулиар хүлээсэн, энэ үүргийг биелүүлээгүй болохыг эрх бүхий албан тушаалтан илрүүлж зөрчилд тооцон арга хэмжээ авч, шийтгэл оногдуулсан нь хуульд нийцсэн” гэх үндэслэлээр гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.
- 2. Давж заалдах шатны шүүхээс:** анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.
- 3. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс:** “...Зээлийн шугамын гэрээнд заасан зээлийн хэмжээний дагуу хэд хэдэн удаагийн үйлдлээр зээлийн олголтыг хуваан авсан нь тус тусдаа зээлийн харилцаа үүсгэж буй хэлбэр биш ... Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолууд захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй ...” зэрэг үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргасан.
- 4. Хяналтын шатны шүүхээс:** “хэм хэмжээний акт нь тухайн харилцаанд оролцогчдод чиглэсэн нийтлэг зохицуулалт агуулсан, шалгуур, үйл ажиллагааны шат дараалал, цаг хугацаа тогтоосон байдаг бөгөөд ирээдүйд үүсэх ижил тохиолдолд дахин давтагдан хэрэглэдэг зэрэг шинжүүдээрээ хуультай адилтгах эрх зүйн эх сурвалж болдог. Энэ нь нэг талаас, тухайн хэм хэмжээний актын үйлчлэл чиглэсэн (улсын хэмжээнд, аль нэг засаг захиргаа, нутаг дэвсгэрт эсхүл тодорхой салбарын) хүрээнд хамаарч буй бүх этгээдэд үйлчлэх шинжтэй хэм хэмжээ тогтоосон байх; нөгөө талаас, уг хэм хэмжээний актаар зохицуулагдах харилцаанд оролцох тодорхой бус тооны этгээдэд үйлчлэх дахин давтан хэрэглэгдэх шинжтэйгээрээ захиргааны актаас ялгагддаг. (16)⁶
- 5. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дээрх** “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам” түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь нийтэд буюу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд чиглэсэн, байнга давтагдах шинжтэй, үйл ажиллагааны нөхцөл шаардлагыг тодорхойлж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд нь хяналт тавих зэрэг харилцааг зохицуулснаараа эрх зүйн үр дагавартай захиргааны хэм хэмжээний актын шинжийг бүрэн агуулсан байна. (18)

⁴ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)-ийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг “Нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу хангаж биелүүлнэ”.

⁵ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг “Санхүүгийн зохицуулах хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хяналт тавьж, шалгалт хийнэ”.

⁶ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



6. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн лавлагааны хуудсаар Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, тус журамд 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 78 дугаар тогтоолоор оруулсан **нэмэлт, өөрчлөлт захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлгүй нь тогтоогджээ.** (21)
7. ...гомдол гаргагчид **шийтгэл оногдуулах хууль зүйн үндэслэл болсон ...** “Банк бус, санхүүгийн үйл ажиллагаа болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих **журам” нь** Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон журмын дагуу захиргааны **хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэгдээгүй, хүчин төгөлдөр болоогүй тул эрх зүйн үр дагаваргүй,** иймд тухайн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэж шийтгэл оногдуулах үндэслэлгүй юм. (24)
8. Дээрх үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн.